



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/44

Ховд

Зарим арга хэмжээг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “л” заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт болон шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор удахгүй болох сар шинийн баярын үеэр хүчит бөхийн барилдаан, хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ